



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 22 өдөр

Дугаар А/518

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Засгийн газрын 2015 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн “Жагсаалт батлах тухай” 336 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар стандартын шаардлага хангасан, тохирлын баталгаатай барааны жагсаалт”-ын 8.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлын хүрээнд “Өв агро гурил тэжээлийн үйлдвэр” орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн тариалсан ногоон тэжээлээс аймгийн аюулгүйн нөөцөд 10.0 мянган боодол ногоон тэжээлийг тээвэрлэн ирсэн автомашины тээврийн зардал 15,000,000 (арван таван сая) төгрөг, тээвэрлэн ирсэн ногоон тэжээлийн буулгалтын зардал 1,500,000 (нэг сая таван зуун мянга) төгрөг, нийт 16,500,000 (арван зургаан сая таван зуун мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Ногоон тэжээл тээвэрлэн ирсэн жолооч, буулгасан иргэдтэй гэрээ байгуулж, ногоон тэжээлийн чанар, баглаа боодол зэрэгт хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (С.Цэдэнбалжир)-д даалгасугай.

3. Дээрх ногоон тэжээл тээвэрлэсэн болон буулгасан зардал 16,500,000 (арван зургаан сая таван зуун мянга) төгрөгийг өвс, тэжээлийн аюулгүйн нөөц бэлтгэх хөрөнгийн эргэн төлөлтөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101094